



УЛААНБААТАР
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

Чингисийн өргөн чөлөө 45, 3 дугаар хороо,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 17060
Утас: 34 16 74, Факс: (976-11) 34 30 61,
Цахим шуудан: info@ubedn.mn, Цахим хуудас: www.tog.mn

2024.11.15 № 1/2015
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Манай компаниас зарлагдсан УБЦТС/20240101242 дугаартай "Ухаалаг тоолуурын систем нэвтрүүлэх төсөл" бараа нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерт ирүүлсэн тодруулгын хариуг дараах байдлаар хүргүүлж байна.

Тодруулга 1:

Манай хятад компанитай түншлэлээр тендер ирүүлж байгаа уг тендерийн шалгуур үзүүлэлт болох түргэн хөрвөх чадварын шалгуурт үнийн дүнгийн 80%- аас багагүй байна гэсэн байна. Тэгэхээр 2 компани оролцож байгаа өөрсдийн % -иараа энэ үзүүлэлтийг хангана гэж ойлгох уу. 60 : 40 орж байгаа бол 2,4 тэрбум , 1,6 тэрбум гэсэн үг үү.

Хариулт 1:

Тендерийн баримт бичгийн ТШЗ -ын 19.1-ийн 4 дүгээр шаардлагын 4.4-т "Төлөөлөх эрх бүхий гишүүн түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнгийн 40 ба түүнээс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна." гэж нэмж тусгав.

Тодруулга 2:

Цахим тендерийн баталгааны хүчинтэй хугацаа болон хүний нөөцийн маягтыг тодруулан ирүүлж өгнө үү.

Хариулт 2.1:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-р зүйлийн 14.8-д "Тендерийн баталгаа нь гэрээ байгуулах хүртэл, эсхүл тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаанд хүчинтэй байна" гэж заасны дагуу захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ -ын 24.1-ийн шаардлага, тендер шалгаруулалтын зарлалын 6-д дараах заалтуудыг нэмж оруулж байна. Үүнд:

1. Тендерийн баталгаа нь тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
2. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 өдрийн хугацаанд хүчинтэй байна.

Хариулт 2.2:

Тендерийн баримт бичгийн V бүлэгт Хүний нөөцийн маягт 7 -г нэмж оруулав.

Тендерийн баримт бичигт дээрх нэмэлт заалтуудийг тусган шинэчилсэн байдлаар цахимд байршуулсан тул та бүхэн тендерийн материал бэлдэх явцдаа анхаарч, шаардлагад нийцүүлэн ажиллахыг хүсье.

Та бүхэнд амжилт хүсье.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



КЭРДЭНЭБАЯР